



Шинжээчийн үнэлгээний тайлан

Байгууллагын нэр: ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА
ДҮРСЛЭХ УРЛАГ ДИЗАЙН ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ

Хөтөлбөрийн нэр: АРХИТЕКТУР

Индекс: D073101

Шинжээчийн баг:

Ахлагч:	Б.Загдхорол	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Эрчим хүчний сургуулийн цахилгаан техникийн салбарын дэд профессор, доктор
Гишүүд:	Б.Дуламсүрэн	Хөдөө аж ахуйн их сургуулийн Инженер технологийн сургуулийн Машин судлалын тэнхимийн эрхлэгч, техникийн ухааны доктор
	С.Даланжаргал	Хот байгуулалт хөгжлийн газар Хот төлөвлөлтийн хэлтсийн дарга, доктор

Агуулга

Товчилсон үг, нэр томъёоны тайлбар.....	3
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт.....	4
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	5
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт.....	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа.....	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	10
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	12
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	14
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа.....	17
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	19
Дүгнэлт.....	22
Нэгдсэн зөвлөмж.....	23
IV. Уулзалтад оролцогчдын нэрс.....	24
I. Багш нарын нэрс.....	24
II. Оюутнуудын нэрс.....	25
III. Ажил олгогчдын нэрс.....	26
IV. Төгсөгчдийн нэрс.....	27
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	28

ТОВЧИЛСОН ҮГ, НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

1. ИЗОУИС – Их Засаг Олон Улсын Их Сургууль
2. ДУДТДС – Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Дээд Сургууль
3. ЭШИА – Эрдэм шинжилгээ, инновацийн алба
4. СБЗА – Сургалт, бодлого, зохицуулалтын алба
5. (PEO) - Program educational objectives Боловсролын хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтууд
6. (PLO)- Program Learning outcomes - Хөтөлбөрийн үр дүн
7. БСШУЯ – Боловсрол соёл шинжлэх ухааны яам
8. БАС – Барилга архитектурын сургууль
9. ШУТИС – Шинжлэх ухаан технологийн их сургууль
10. ОХУ – Оросын Холбооны Улс
11. АНУ – Америкийн Нэгдсэн Улс
12. БНХАУ – Бүгд Найрамдах Хятад Ард Улс
13. АХБ – Азийн хөгжлийн банк
14. ААН – Аж ахуйн нэгж
15. БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Их Засаг Олон Улсын Их сургуулийн харьяа Дүрслэх Урлаг Дизайн Технологийн Дээд сургууль Fine art and design technology institute	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Архитектур Architecture	
Индекс	073101	
Шинжээчид	Ахлагч: Б.Загдхорол Гишүүд: Б.Дуламсүрэн С.Даланжаргал	
Зохицуулагч	Б.Сүнжидмаа Магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2021.11.24	Ажлын албаны захирлын тушаалаар томилогдсон. №А/139
	2021.11.23	Ажлын албаны захиралтай гэрээ байгуулсан.
	2021.12.06	Урьдчилсан үнэлгээний тайланг ажлын албаны мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн.
	2021.12.09-10	Сургууль дээр илрэл нотолгоотой танилцаж, уулзалт хийсэн.
	2021.12.20	Шинжээчийн багийн тайланг ажлын албанд хүлээлгэн өгсөн.
	2021.12.22	Шинжээчийн багийн тайланг сургуульд илгээн санал авсан.
	2021.12.28	Шинжээчийн баг тайланг эцэслэн боловсруулж, ажлын албанд хүлээлгэн өгсөн.

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн тодорхойлолт

Архитектур мэргэжлийн онцлогийг тусгаж, барилгын хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлох, инновацийн тогтолцоот хандлагыг харгалзан, зохион бүтээх авьяас техникийн сэтгэлгээг хөгжүүлэх, онолын болон дадлагын харьцааг оновчтой тогтоож, орон сууц, олон нийтийн барилгын ажиллаж, амьдрах орчны архитектур, орон зайн төлөвлөлт боловсруулах, суурин газрын ерөнхий төлөвлөгөөний санаа гаргах, оновчтой шийдлийг эскиз болон ажлын зураглалаар илэрхийлэх чадвартай болж зураг төслийн байгууллагад зураг төслийн ажлыг удирдах, судалгааны багт орж ажиллах, зохион байгуулах, бие даан уран бүтээл хийх, шинийг санаачлах, гоо зүйн өндөр боловсролтой ёс зүйг эрхэмлэн дээдлэгч нэр хүнд бүхий мэргэжилтэн болно.

Зорилго

ИЗОУИС-ийн зорилго: Их Засаг Олон Улсын Их сургуулийн мэдлэгийг үйлдвэрлэгч, баялгийг бүтээгчдийг төрүүлэх, оюутан суралцагчдын ажил амьдралын баталгааг хангахад чиглэгдсэн **сургалт, судалгаа**, инновацын **бүтээлч чадамжтай, судалгааны их сургууль байна.**

ДУДТДС-ийн зорилго: Дүрслэх урлаг, дизайн, технологийн мэргэжлээр чадварлаг, **бүтээлч** сэтгэлгээтэй судлаач мэргэжилтнийг бэлтгэж, **төрөөс баримтлах соёл урлагийн бодлогыг хэрэгжүүлэгч**, үндэсний өв соёлоо түгээн дэлгэрүүлэгч, **сургалт – судалгаа – үйлдвэрлэл** дизайны сургууль байхад оршино.

Архитектур хөтөлбөрийн зорилго: **Төрөөс баримтлах** барилга **соёл урлагийн бодлогыг хэрэгжүүлэгч**, бүтээлч оролцоотой, **судалгаанд суурилсан**, багаар ажиллах чадвартай, эерэг хандлагыг бий болгоно.

Хөтөлбөрийн зорилтууд PEO (Program Educational Objectives)

1.2 дугаар хүснэгт

Д/Д	ЗОРИЛТ (PEO)
1	Эх хэл, түүх соёлоо эрхэмлэн дээдлэгч, үндэсний уламжлалт мэдлэгийг түгээн дэлгэрүүлэгч, барилга архитектурын суурь мэдлэг чадвартай байх
2	Монголын архитектурын урлагийн суурь, мэдлэг судлан шинжлэх, чадварыг эзэмшүүлэх
3	Бүтээлч сэтгэлгээтэй, шинжлэн судлах, асуудлыг шийдвэрлэх чадвартай, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй, харилцааны ур чадваруудыг эзэмшүүлэх
4	Оюутан бүрийн хөгжил, төлөвлөлтийн онцлогийг судалдаг, ялгаатай байдалд нь хүндэтгэлтэй ханддаг, тэдний ахиц амжилт, хөгжлийг дэмжих
5	Багаар ажиллах, харилцах, хамтран суралцах чадвартай, нийгмийн амьдрал, байгууллын зүй тогтол, эрх чөлөө, үнэт зүйлс, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэгч
6	Барилгын салбарыг өргөн утгаар нь ойлгож архитектур мэргэжил, үүргийг ухамсарлан, мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах чадамжтай.
7	Архитектурын мэргэжлийн боловсролын арга зүйг эзэмшиж, урлагийн гоо сайхныг мэдэрч хүндэтгэдэг, соёлын өв, дурсгал, уламжлалт хийц, эдлэлээ хайрлан хамгаалдаг, орчин үеийн шинэлэг загвар бүтээх эрэлхийлэх чадамжтай, эерэг хандлагатай, эко дизайны талаар судалж боловсруулах технологийг сонгох арга барилд суралцах
8	Үйлдвэрлэл, бизнес, байгууллагын хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, бүтээх, удирдан манлайлах, оюуны өмчийг бүтээн туурвих, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах мэргэжилтэн бэлтгэх, өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх арга зүй, аргачлал, аргыг мэддэг үйл, ажиллагаандаа хэрэглэдэг, асуудал шийдвэрлэх чадвартай.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн PLOs (Program Learning Outcomes)

1.3 дугаар хүснэгт

Д/Д	ХҮРЭХ ҮР ДҮН (PLO)
1	Барилгын салбарын түүх соёлоо эрхэмлэн дээдлэгч, үндэсний өв уламжлалаа түгээн дэлгэрүүлэгч, архитектурын мэргэжлийн анхан шатны мэдлэгтэй болох
2	Монголын архитектурын суурь мэдлэг судлан шинжлэх чадварыг эзэмшсэн байх
3	Бүтээлч сэтгэлгээтэй, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чадвартай, хариуцлагатай, мэргэжлийн ёс зүйтэй, харилцааны үр чадваруудыг эзэмшсэн байх
4	Оюутан бүрийн онцлогийг судалдаг, ялгаатай байдалд нь хүндэтгэлтэй ханддаг, тэдний ахиц амжилт, хөгжлийг тогтмол дэмждэг байх
5	Багаар ажиллах, харилцан хамтран суралцах чадвартай, нийгмийн амьдрал, байгууллын зүй тогтол, эрх чөлөө, үнэт зүйлс, эрүүл аж төрөх ёсыг эрхэмлэн дээдлэгч болох
6	Барилгын салбарыг ойлгодог, архитектур мэргэжлийн чиг үүргийг ухамсарласан, мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах чадамжтай болох
7	Архитектурын мэргэжлийн боловсролын арга зүйг эзэмшиж, урлагийн гоо сайхныг мэдэрч хүндэтгэдэг, соёлын өв, дурсгал, уламжлалт хийц, эдлэлээ хайрлан хамгаалдаг, орчин үеийн шинэлэг загвар бүтээх эрэлхийлэх чадамжтай, эерэг хандлагатай, эко дизайны талаар судалж боловсруулах технологийг сонгох арга барилд суралцсан байх
8	Байгууллагын хүрээнд зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, бүтээх, удирдан манлайлах, оюуны өмчийг бүтээн туурвих, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангах мэргэжилтэн бэлтгэх, өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх арга зүй, аргачлал, аргыг мэддэг үйл, ажиллагаандаа хэрэглэдэг, асуудал шийдвэрлэх чадвартай байх

Сургалтын төлөвлөгөөний бүтэц

Архитектур хөтөлбөр нь БСШУ-ны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ын дагуу боловсруулагдсан ба сургалтын төлөвлөгөөг ШУТИС-ийн БАС-ийн Архитектур хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, ЮНЕСКО /UIA АРХИТЕКТУРЫН БОЛОВСРОЛ-ын тунхаглал, зорилгыг судалсны үндсэн үндсэн дээр мэргэжлийн хичээлийн цагийг нэмэгдүүлж **132 багц цаг** /заавал үзэх **118 кр**, сонгон суралцах **14 кр**/ судлахаар өөрчлөлт оруулсаныг ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны 06 сарын 5-ны өдрийн №2 тоот хурлаар хэлэлцэн батласан.

Хөтөлбөр нь дараахь хэсгүүдээс тогтоно:

- Ерөнхий суурь хичээл **38** багц цаг (29.9%) байна. Үүнээс **34** багц цагийг заавал судлах байдлаар, үлдсэн **4** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэжлийн суурь хичээл нийт **34** багц цаг (26.7%) байна. Үүнээс **28** багц цагийг заавал судлах байдлаар, **6** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.
- Мэргэжлийн хичээл **45** багц цаг + 10 багц цаг дадлага, төгсөлтийн ажил (43.3%) байна. Үүнээс **37** багц цагийг заавал судлах байдлаар, **8** багц цагийг санал болгож буй хичээлээс сонгон судална.

2.5 дугаар хүснэгт

Хөтөлбөрийн улирлын цагийн ачаалал

Улирал	Кредит	Нийт цаг	Лекц	Сем/дад	Лаборатори	Дадлага	Бие даалт
I – I	17	384	160	224	0	0	272
I – II	15	448	64	288	0	96	208
II – I	20	480	160	288	32	-	320
II – II	18	512	96	320	0	96	256
III – I	18	432	144	224	64	-	288
III – II	22	592	120	224	64	144	304
IV	22	752	112	160	0	240	196
Нийт	132	3600	856	1728	180	576	1844

**ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн архитектур
хөтөлбөрөөр суралцагчид, төгсөгчдийн тоо**

Үзүүлэлт	Хичээлийн жил				
	2016-2017	2017-2018	2018-2019	2019-2020	2020-2021
Нийт суралцагчдын тоо	232	300	332	273	320
Архитектур хөтөлбөрөөр суралцагчдын тоо	146	171	149	122	124
Төгсөгчдийн тоо	56	45	28	27	42

Тухайн хөтөлбөр нь нийт 23 багштай үүнээс доктор 4, магистр 19 багш ажиллаж байна. Мэргэжлийн хичээл заадаг багш нар бүгд магистр зэрэгтэй, ОХУ-аас 2 багш, Хятад Улсаас 1 багш тус тус ажилладаг.

Архитектурын тэнхимийн багшийн зэрэглэл

Хичээлийн жил	Профессор багш	Ахлах багш	Багш	Дадлагажигч багш
2016-2017	4	4	5	4
2017-2018	4	10	8	2
2018-2019	4	12	7	4
2019-2020	4	10	6	3
2020-2021	4	12	7	-

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд хийсэн дүн шинжилгээ, ажлын төлөвлөгөө, бенчмарк, судалгааны танилцуулга /PEST, STEEP гэх мэт/
- Гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, бенчмарк

Онцлог зүйл/Туршлага:

- ШУТИС, Сити болон ОХУ-ын их сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байна.
- STEEP шинжилгээ хийсэн байна.
- ОХУ-ын Барнаулын их сургуулийн хөтөлбөрийн харьцуулалт хийн хөтөлбөрт тусгасан.

Зөвлөмж:

- Бенчмаркийг TOP сургуулиудтай жишиг болгон харьцуулалтыг тогтмол хийх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон баримт бичиг
- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын зорилго, зорилтын хоорондын уялдаа холбоог гаргасан.
- Сэтгэл ханамжийн судалгаа хийж, ЛИКЕРТ-ийн хэмжүүр хийсэн.
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар боловсруулахдаа ЮНЕСКО-ийн Тогтвортой хөгжлийн 17 зарчмыг үндэслэн хөтөлбөрийн зорилго зорилтдоо тусгасан байна.
- Архитектурт мэргэжилд тавигдах шаардлагад ЮНЕСКО /UIA АРХИТЕКТУРЫН БОЛОВСРОЛ-ын тунхаглалыг тусган боловсруулсан.

Зөвлөмж:

- Оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч боловсруулалт хийдэг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны 06 сарын 5-ны өдрийн №2 тоот хурлаар хэлэлцэн батлагдсан хөтөлбөр
- Хурлын тэмдэглэл
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, график /матриц/
- Батлагдсан хичээлийн хөтөлбөр

Онцлог зүйл/Туршлага:

- 2014, 2018 онуудад хөтөлбөрийг шинэчлэх, баталгаажуулах үйл ажиллагааг тогтмол явуулж байсан
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт, хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтуудын уялдаа холбоог гаргасан
- CDIO сургалтын арга зүйг сургалтандаа нэвтрүүлж сургалт явуулж байна.

Зөвлөмж:

- Оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг хөтөлбөрт тусган тогтмол сайжруулдаг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн индекс, хичээлийн суралцахуйн үр дүнгийн матриц
- Удирдлагын мэдээллийн систем дэх сонголтууд
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд хийсэн шинжилгээ
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан, анализ

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөг 2014, 2018 онуудад шинэчлэн сайжруулсан.
- Дадлагын талаар хамтран ажиллах гэрээ, санамж бичиг, удирдамж, журам, ажлын тайлан гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа байгаа хэдийд ч оновч муутай, тодорхой бус байна. Тухайлбал: 3,4 курсын хичээлүүдийг намар хаврын улиралд хуваан судладаг байх

Зөвлөмж:

- Хичээлийн уялдаа холбоог сайн хийх нь сургалтын чанарт ахиц дэвшил гарна. Тухайлбал: Монголын түүхийн хичээлийг /тухайн хичээлийг 4 курст судладаг/ судласны дараа Архитектурын түүх хичээлийг судладаг байх.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын аргазүйг хэрэгжүүлэх загвар, заавар, зөвлөмж
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт материал

Онцлог зүйл/Туршлага: -

- Сургалтын CDIO арга зүй хэрэгжүүлэхэд анхаарсан хөтөлбөрт тусгасан.
- Сургалтын аргазүйд хийсэн анализ судалгааны баримт байна.

Анхаарах асуудал:

- Математик 1 хичээл сургалтын төлөвлөгөөнд сонгон байдлаар тусгагдсаныг заавал судалдаг байхаар төлөвлөгөөнд тусгах. Математик, физикийн хичээлийн суурь тавигдснаар инженерийн суурь чадварыг олгоно.

Зөвлөмж:

- Инженерээр хөрвөх мэргэжилтэн бэлтгэхэд шаардагдах туршлага чадварыг тодорхойлох, улмаар төгсөгчдийн загвараар дамжуулан хөтөлбөрт тусгах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтад ашиглаж буй үнэлгээний аргазүйн судалгаа. /Блум таксономи, Рубрик арга г.м/
- Хичээл нэг бүрийн үнэлгээнд хийсэн дүн шинжилгээ, анализ /Шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд хийсэн шинжилгээ/
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журам
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх статистик мэдээлэл, боловсруулалт, дүгнэлт /голч дүн, хичээлд унасан оюутны тоо, амжилт, чанар г.м/

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын үйл ажиллагаанд гүйцэтгэлийг Рубрикийн аргаар үнэлж байна.
- Архитектур, дизайн 2 хичээлийн үйл ажиллагаанд үнэлгээний матриц хийсэн байна.
- Оюутны идэвхийг сайн үнэлдэг.

Зөвлөмж:

- Оюутны идэвхийг сайн үнэлдэг ч хичээлийн суралцахуйн үр дүнг хянаж сайжруулдаг байх.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, урлан, бие даан болон багаар ажиллах орчны хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа
- ИЗОУИС-ийн харьяа ДУДТДС нь 2016, 2018 онуудад хичээлийн 2 болон 3 байруудыг ашиглалтанд оруулсан байна. Байруудад лекц, семинарын 2 танхим, лаборатори 4, урлан 10, мэргэжлийн номын сан болон багш нарын 2 өрөө байрладаг.
- Үүнээс Архитектурын тэнхим нь уг байруудад лаборатори 4, лекцийн танхим 2, урлангийн 8 өрөөг ашигладаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Шинээр хичээлийн байр барихаар зураг төслийг боловсруулсан. Төсвийн асуудлыг шийдэхээс бусад ажил хийгдсэн.

- Сургалтын болон хэвлэлтийн тоног төхөөрөмжүүдээр хангагдсан. Хэвлэлт тоног хэрэгслээр бүтээгдэхүүн хэвлэн брэнд үйлчилгээг нэвтрүүлсэн. Төгсөлтийн ажил, сурталчилгаа, зарим хичээлийн төслийн ажилд хэрэглэгддэг.
- Барилгын материал, барилгын хийцийн лабораторийг ШУТИС дээр гэрээний дагуу очиж хийдэг.

Зөвлөмж:

- Шинэ байр барих асуудлыг хурдан шийдвэрлэхэд анхаарч, анги, танхим, лабораторийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Е-контент түвшинд боловсруулсан сургалтын материал

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт гаргасан
- Е-контент түвшинд боловсруулсан сургалт youtube-д байршуулсан
- Хот төлөвлөлтийн болон макет урлал, технологийн лаборатори, компьютерийн лаборатори болон CDIO өрөө байдаг.
- Тухайн лаборатори, урлан, номын сан зэрэгт оюутнууд чөлөөтэй нэвтэрч суралцах хугацаа хангалттай тавьж өгдөг.

Анхаарах асуудал:

- Оюутнуудын хэрэглэх компьютерийн хүртээмж, лицензтэй программ хангамжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Цахим сургалтын чанарыг сайжруулах, цахим хичээлд хэрэглэж байгаа платформуудыг судлан хичээлд нэвтрүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн жагсаалт, сэтгэл ханамжийн судалгаа.
- Мэргэжлийн ном, сурах бичгийн баяжилт, шинэчлэлтийн судалгаа
- Цахим мэдээллийн сан, нээлттэй эх үүсвэрийн ашиглалтын судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн үзүүлэлт, багшийн вэбэд тулгуур сурах бичгийн мэдээлэл оруулсан.

- Номын сангийн нэгдсэн lib4 нэвтрүүлсэн.
- Мэргэжлийн ном сурах бичиг хангалттай.

Зөвлөмж:

- Цахим номын сан, цахим хичээлийн материал, мэдээлэл тогтмол явуулж хөгжүүлэлт байнга хийдэг эсэхийг судалгааны боловсруулалтанд оруулан дүгнэх
- Багш нарын өөрсдийн зохиосон сурах бичигтэй болох

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан
3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хороо, профессорын баг, тэнхимийн хурлын шийдвэр, тэмдэглэл
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой эрхзүйн баримт бичиг, эрхзүйн баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Хөтөлбөрт ирсэн санал гомдол, шийдвэрлэлтийн тайлан
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн урт, дунд, богино хугацааны тайлан, төлөвлөгөө.
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ
- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдалд хийсэн дүн шинжилгээ

Онцлог зүйл/Туршлага:

- Тэнхим нэгжийн урт, дунд, богино хугацааны тайланг дүгнэсэн.
- Оюутны санал гомдол шийдвэрлэсэн судалгаа оруулсан байна.
- Дотоод удирдлага мэдээллийн систем ашигладаг ил тод байдлыг хангасан.

Зөвлөмж:

- Удирдлагын зүгээс ажлын гүйцэтгэл, шийдвэрлэх асуудалд төлөвлөгөө гарган нэг системд оруулан, хяналт тавин ажиллах (PCDA-ийн хэрэгжүүлэлтийг сайжруулах)
- Тайлан төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнд хяналт хийлгүүлдэг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн гэрээ, хэлцэл, ажлын тайлан

- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоон судалгаа, дүрэм журам
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо, үр дүн, ажлын тайлан, дүгнэлт /багш, суралцагчдын зүгээс/
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны баримт материал
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээлэл

Онцлог зүйл/Туршлага:

- Хамтын ажиллагааны хүрээнд хийсэн ажлын нэрс, үр дүнг хүснэгтээр оруулсан.
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээ арга хэмжээ 12 зохион байгуулсан.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үзүүлэлт сайтай, төгсөгчдийн холбоо байгуулан их сургуулийн хэмжээнд ажилладаг.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн холбоотой хамтарсан ажлуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн сайжруулалтанд ашиглах
- Суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсад, төгсөгчдийг давтан сургалтад хамруулсан талаарх тоон мэдээллийг гаргах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн жилийн төсөв, зарцуулалтын тайлан
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Сургалтын төлбөрөөс хөтөлбөрт зарцуулагддаг хувь хэмжээ, үр дүнгийн судалгаа
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв, төсвийн зарцуулалт
- Төр, хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалтын тайлан

Онцлог зүйл/Туршлага:

- Нэгжийн санхүүгийн орлого зарцуулалтыг оруулсан байна.
- Төрөөс дэмжлэг, санхүүгийн хөнгөлөлт авдаггүй. Оюутны төлбөр, байгууллагын бусад орлогоос санхүүждэг.

Зөвлөмж:

- Багш, оюутнуудын тэтгэлэг, урамшууллыг ил тод байлгаж, үйл ажиллагаанд оролцогчдод ахиж дэвших боломж олгох

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Тандан судалгаа, дүгнэлт, холбогдох материал
- Хийсэн ажил, арга хэмжээ, тайлан, барим

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн сурталчилгаа идэвхжүүлэлтийн арга хэмжээ их зохион байгуулдаг.
- Хар зургийн дугуйлан хичээллүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжээс гаргасан сонин, сэтгүүл, ном товхимол гарын авлага, цахим мэдээллийн жагсаалт
- Вeбсайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж үйл ажиллагааг вэб хуудсаар харуулсан байна.

Зөвлөмж:

- Цахим мэдээлэл болон вебсайтыг иж бүрэн байдал, тогтмол ажиллагаанд хяналт тавьж, сайжруулдаг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Элсэлтийн бодлого, дүрэм журам
- Элсэгчдийн ерөнхий шалгалтын дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа.
- Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл, гарын авлага
- Гадаад оюутны элсэлтийн тоо

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутан элсүүлэх журмаар зохицуулагддаг.
- Ур чадварын нэмэлт шалгалт авдаг. Шинэ суралцагчдад зориулсан мэдээлэл гарын авлагатай.

- Шинээр элсэн орсон суралцагчдыг сургалтын алба, оюутан хариуцсан багш нар хүлээн авч групп үүсгэн түргэн шуурхай мэдээллээр хангадаг.
- Ур чадварын ялгаатай байдлыг арилгах зорилгоор тухайн төвшний сургалтыг зохион байгуулдаг.

Зөвлөмж:

- Гадаад оюутны элсэлтийг нэмэгдүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, тайлан
- Сэтгэл ханамжийн судалгаа, баримт материал
- Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тайлан мэдээ.
- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл/Туршлага:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээ үзүүлдэг. Оюутанд үзүүлж буй үйлчилгээг хувьчилан үзүүлсэн.
- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг оруулсан.
- Оюутны холбоо идэвх зүтгэлтэй ажилладаг.
- Оюутнуудын сурах, хөгжих талаар жил бүр сургалт, соёл, хүмүүжлийн талаар олон нийтийн ажил төлөвлөгөө боловсруулан зохион байгуулдаг.
- Оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг жил бүр авдаг.

Зөвлөмж:

- Оюутнуудын эрдэм шинжилгээ судалгааны ажлын жагсаалтын тогтмол хөтлөх
- Сэтгэл ханамжийн судалгааны дагуу үйл ажиллагаа, материаллаг баазаа шинэчилж хөгжүүлсэнээ олон нийтэд болон суралцагчдаа сурталчилдаг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны клубийн зохион байгуулсан арга хэмжээ, тайлан мэдээ
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлын үнэлгээ, урамшуулал
- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл

Онцлог зүйл/Туршлага:

- Байнгын ажиллагаатай 5 хороо, клуб ажилладаг.

- БСШУЯамнаас АХБ-ны зээлийн санхүүжүүлэлтээр хэрэгжүүлсэн “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл” хүрээнд зохиогдсон Засгийн газрын тэтгэлэгт төсөлд 2016-2017 онд Нано нэгдэл төсөл тэнцэж, төслийг хэрэгжүүлсэн.
- 2016-2021 оны хооронд 5 төрлийн 64 удаагийн тэтгэлэгт 300 гаруй оюутан хамруулсан. Үүний 50% архитектурын ангийн оюутан байна.
- Цагийн ажил, үндсэн ажилд зуулчилдаг давуу талтай.

Зөвлөмж:

- Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл, урамшууллын мэдээллийг тогтмол гаргадаг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журам

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгаа хийсэн байна.
- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний судалгаа, дүрэм журамтай

Зөвлөмж:

- Шилжилт хөдөлгөөнийг багасгахаар хичээлийн уялдаа холбоог алдагдуулахгүй байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөлтийн баримт бичгийн загвар
- Төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийн байдал

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөлтийн ажил бичих заавар, төгсөлтийн бичиг баримт олгох заавар журамтай.
- Төгсөлтийн ажил бүтээл хийн дүгнүүлдэг, захирлын шийдвэр тушаалын дагуу зохион байгуулагддаг.
- Төгсөгчдийн өдөрлөг зохион байгуулж ААН, байгууллагуудад санал тавьдаг.
- Төгсөлт нь сургуулийн журам заасны дагуу төгсөлт хийн бичиг баримт хөтөлдөг.

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн ажлын бичвэрийг тавьсан шаардлагын дагуу бүрэн гүйцэтгүүлэх, үг үсгийн алдаа, найруулга дэс дарааллыг баримтлах. Төгсөлтийн ажлын бичвэрт судалгааг сайн оруулах

Зөвлөмж:

- Төгсөлтийн ажлын бичвэрийг чанарыг сайжруулах, журмын дагуу бичих, бичиг баримт боловсруулах чадвартай мэргэжилтэн болохын тулд анхааран ажиллах.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан
5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг ИЗОУИС-ийн дүрэм журамд тусгагдсан
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагын журмаар зохицуулагддаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Магистр зэрэгтэй багшлах боловсон хүчний нөөц сайн. Мэргэжлийн ур чадвар (архитектур) сайн. Архитектурчдын гранприг 2017, 2018 онуудад 2 удаа авч байсан.
- ОХУ-ын Архитектур мэргэжлийн магистр 2 багш, Хятад хэлний Хятад -1 багштай

Анхаарах асуудал:

- Доктор багш - 4, үүнээс архитектур мэргэжлийн доктор багш байхгүй. График дизайн, хөдөлмөр, зураг технологи, загвар зохион бүтээгч, түүх газар зүйн гэсэн 4 доктор багштай. Докторын эзлэх хувийг нэмэгдүүлэх- 16,6%
- Багш нарын цагийн ачаалал тооцсон судалгаа байхгүй.

Зөвлөмж:

- Архитектур мэргэжлийн доктор багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, залуу багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх, багш нарын ачааллын судалгаа баримт бичгийн хөтлөлт, багш нарт урамшууллыг олгодог, дэмжлэг үзүүлсэн судалгааг гаргадаг байх

Шаардлага:

- Архитектур мэргэжлийн доктор багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, залуу багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш хөгжлийн төв байгуулсан байна.
- Багш бүр урт, дунд, богино хугацааны төлөвлөгөөтэй.

Онцлог зүйл/Туршлага:

- "Багш хөгжлийн төв" 2018 онд байгуулсан байна. Багш хөгжлийн өрөөтэй.
- Уралдаан, тэмцээнд багш нар оюутнуудаа удирдан оролцдог, Энэ нь ур чадвараа дээшлүүлэх, туршлага судлахад ихээхэн ач холбогдолтой.

Зөвлөмж:

- Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэлтийг тогтмолжуулах
- Багшийн суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа хийх, багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Бодлогын баримт бичиг, дүрэм журамтай
- Хэрэгжүүлсэн төсөл, нийтлэгдсэн бүтээл, өгүүлэлтэй танилцлаа.

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын болон дотоодын их дээд сургууль, эрдэм шинжилгээний хурал, урлаг соёлын байгууллагатай хамтарсан үзэсгэлэн, уралдаанд оролцдог байна. Өгүүлэл хэвлүүлсэн, илтгэл хэлэлцүүлсэн ажил харьцангуй бага.

Анхаарах асуудал:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, ашигтай загвар, патент, эшлэгдсэн тоо байхгүй.
- Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын тайлан мэдээг тодорхой гаргадаггүй.

Зөвлөмж:

- Багш бүр бүтээлийн жагсаалтаа гаргадаг байх, зураг төслийн бүтээлээ баримтжуулах, бичиг баримт хөтлөдөг байх
- Эрдэм шинжилгээ судалгааны ажилд идэвхитэй оролцдог байх

Шаардлага:

- Багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажилд идэвхитэй оролцдог байх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үнэлэх дүгнэх журамтай
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хавтас

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн үнэлгээг А+Б+В цагаар үнэлдэг. Багшийн өөрийн үнэлгээний тайланг бичиж тайлагнадаг. Багшийн өөрийн үнэлгээний тайланд PDCA шинжилгээ хийдэг
- Багшийн баримт бичиг, зарим хичээлүүдийн хөтөлбөр, хичээлийн файлын иж бүрдэлтэй танилцлаа. Тухайлбал: Зураг төслийн автоматжуулалт, Архитектурын түүх, Архитектур төсөл-1,2, Архитектур дизайн, Хот төлөвлөлт-1,2 Барилгын хийц хичээлүүдийн бүрдэлтэй танилцахад бүрдэлт сайн хийгдсэн байна.

Зөвлөмж:

- Сургуулийн зүгээс багш нарт үзүүлсэн нийгмийн үйлчилгээг жагсаалтаар баримтжуулдаг байх

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажуулалт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага, зохион байгуулалтын схем.
- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ

Онцлог зүйл/Туршлага:

- ДУДТДС-ийн Хөтөлбөрийн хорооны зорилго, баримтлах зарчим, бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг үйл ажиллагаа, хэрэгжилт хяналт, шинжилгээний журам боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн чанарын үнэлгээний төлөвлөлт хийсэн, чанарын дотоод баталгаажуулалтын мэргэжилтэнтэй.

Зөвлөмж:

- Чанарын үнэлгээний мэргэжилтэнг сургалтанд хамруулж чадавхжуулах
- Чанарын хяналт шинжилгээг ажлын гүйцэтгэл боловсруулалтыг сайжруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа, дүгнэлт, үр дүн
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа, дүн шинжилгээ

- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээ /Ажил олгогч, мэргэжлийн холбоод, төгсөгч гэх мэт/
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгаа

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа хийсэн. Төгсөгчдийн ажил эрхлэлт 85% нь ажлын байраар хангагдсан. Үүний 70-80% мэргэжлээрээ хувийн байгууллагын инженер, зохион бүтээгч, захирал хийдэг. Мөн төрийн байгууллагад мэргэжилтэн, архитектур хийдэг байна.
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацааны судалгаа авч боловсруулсан.
- Төгсөгчдөөс сэтгэл ханамжийн судалгаа авсан байна.

Зөвлөмж:

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг гаргах, байгууллага болон мэргэжил дээшлүүлэлтийн судалгааг оруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Магадлан итгэмжлэх байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмж, шаардлага, магадлан итгэмжилсэн шийдвэр
- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа, /мэргэжлийн зэрэг, эрхийн үнэмлэх гэх мэт/
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан ажлын тайлан мэдээ.
- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Онцлог зүйл/Туршлага:

- Их засаг олон улсын их сургууль нь “BAC” Их Британийн магадлан итгэмжлэлд 2015 онд, 2019 онд БМИҮЗ-өөр магадлан итгэмжлэгдсэн байна.

Зөвлөмж:

- Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь, тоо судалгааг тогтмол хийдэг байх, судалгааны боловсруулалтаа сайжруулах

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан /х/х, хангаагүй дэд шалгуур байвал үндэслэлийг тодорхой бичнэ./
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	1.1, 1.2, 1.3			
2	Сургалтын ажиллагаа үйл	2.2, 2.3	2.1		
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3.1, 3.3	3.2		
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4.1, 4.2, 4.3, 4.4			
5	Суралцагчид чиглэсэн ажиллагаа үйл	5.1, 5.2, 5.3, 5.4	5.5		
6	Багшийн ажиллагаа үйл	6.2, 6.4	6.1, 6.3		<ul style="list-style-type: none"> - Архитектур мэргэжлийн доктор багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, залуу багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх, багш нарын ачааллын судалгаа баримт бичгийн хөтлөлтийг тогтмол гаргах. - Багш бүр бүтээлийн жагсаалтаа гаргадаг байх, Багш нар эрдэм шинжилгээ судалгааны ажилд идэвхитэй оролцдог байх.
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	7.1, 7.2, 7.3			
ДҮГНЭЛТ		Бүрэн хангасан			

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ

Шалгуур	Зөвлөмж
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> • Бэнчмаркийг TOP сургуулиудтай харьцуулалтыг тогтмол хийж хэвших. • Оролцогч талуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч боловсруулалт хийдэг байх • Хичээлүүд хоорондын уялдаа холбоо, агуулгыг сайжруулахын тулд сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлах
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн уялдаа холбоог сайн хийх нь сургалтын чанарт ахиц дэвшил гарна. Тухайлбал: Монголын түүхийн хичээлийг /тухайн хичээлийг 4 курст судладаг/ судласны дараа Архитектурын түүх хичээлийг судладаг байх. • Инженерээр хөрвөх мэргэжилтэн бэлтгэхэд шаардагдах туршлага чадварыг тодорхойлох, улмаар төгсөгчдийн загвараар дамжуулан хөтөлбөрт тусгах • Суралцагчдын голч дүнг оруулж харьцуулалт хийх.
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	<ul style="list-style-type: none"> • Шинэ байр барих асуудлыг хурдан шийдвэрлэхэд анхаарч, анги, танхим, лабораторийг нэмэгдүүлэх • Цахим сургалтын чанарыг сайжруулах, цахим хичээлд хэрэглэж байгаа платформуудыг судлан хичээлд нэвтрүүлэх • Цахим номын сан, цахим хичээлийн материал, мэдээлэл тогтмол явуулж хөгжүүлэлт байнга хийдэг эсэхийг судалгааны боловсруулалтанд оруулан дүгнэх • Багш нарын өөрсдийн зохиосон сурах бичигтэй болох
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> • Удирдлагын зүгээс ажлын гүйцэтгэл, шийдвэрлэх асуудалд төлөвлөгөө гарган нэг системд оруулан, хяналт тавин ажиллах (PCDA-ийн хэрэгжүүлэлтийг сайжруулах) • Төгсөгчдийн холбоотой хамтарсан ажлуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөтөлбөрийн сайжруулалтанд ашиглах • Багш, оюутнуудын тэтгэлэг, урамшууллыг ил тод байлгаж, үйл ажиллагаанд оролцогчдод ахиж дэвших боломж олгох • Цахим мэдээлэл болон вебсайтыг иж бүрэн байдал, тогтмол ажиллагаанд хяналт тавьж, сайжруулдаг байх
Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Гадаад оюутны элсэлтийг нэмэгдүүлэх • Оюутнуудын эрдэм шинжилгээ судалгааны ажлын жагсаалтын тогтмол хөтөлөх • Сэтгэл ханамжийн судалгааны дагуу үйл ажиллагаа, материаллаг баазаа шинэчилж хөгжүүлсэнээ олон нийтэд болон суралцагчдаа сурталчилдаг байх. • Цагийн ажил, үндсэн ажилд зуучилсан төгсөгч, оюутны тоон мэдээлэл, урамшууллын мэдээллийг тогтмол гаргадаг байх

	<ul style="list-style-type: none"> • Шилжилт хөдөлгөөнийг багасгахаар хичээлийн уялдаа холбоог алдагдуулахгүй байх • Төгсөлтийн ажлын бичвэрийг чанарыг сайжруулах, журмын дагуу бичих, бичиг баримт боловсруулах чадвартай мэргэжилтэн болгохын тулд анхааран ажиллах.
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Архитектур мэргэжлийн доктор багшийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, залуу багш нарыг докторантурт суралцахад дэмжлэг үзүүлэх, багш нарын ачааллын судалгаа баримт бичгийн хөтлөлт, багш нарт урамшууллыг олгодог, дэмжлэг үзүүлсэн судалгааг гаргадаг байх • Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэлтийг тогтмолжуулах • Багшийн суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа хийх, багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх • Багш бүр бүтээлийн жагсаалтаа гаргадаг байх, багш нар зураг төслийн бүтээлээ баримтжуулах, бичиг баримт хөтлөдөг байх • Эрдэм шинжилгээ судалгааны ажилд идэвхитэй оролцдог байх • Сургуулийн зүгээс багш нарт үзүүлсэн нийгмийн үйлчилгээг жагсаалтаар баримтжуулдаг байх
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> • Чанарын үнэлгээний мэргэжилтэнг сургалтанд хамруулж чадавхжуулах • Чанарын хяналт шинжилгээг ажлын гүйцэтгэл боловсруулалтыг сайжруулах • Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг гаргах, байгууллага болон мэргэжил дээшлүүлэлтийн судалгааг оруулах • Дотоод, гадаадын дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь, тоо судалгааг тогтмол хийдэг байх, судалгааны боловсруулалтаа сайжруулах

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Их засаг олон улсын их сургуулийн харьяа Дүрслэх урлаг дизайн технологийн дээд сургууль сургуулийн **“Архитектур”** бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг БМИҮЗ-ийн Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг:.....Б.ЗАГДХОРОЛ
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:.....Б.ДУЛАМСҮРЭН
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг:.....С.ДАЛАНЖАРГАЛ

V. Уулзалт ярилцлагад оролцогчдын бүртгэл

I. Багш нартай хийх уулзалт

№	Овог нэр	Албан тушаалын зэрэглэл	Сургуульд ажилласан жил	Заадаг хичээл	Боловсролын зэрэг	Багш нарын албан тушаалын зэрэглэл	Уулзалтанд
1	Г.Оюун	Багш	3 жил	Архитектур интерьерийн зохиомжийн үндэс, иргэний барилгын интерьер дизайн	Магистр	Архитектурын тэнхимийн багш	Танхим
2	Ө.Сайханаа	Багш	2 жил	Архитектур дизайн, архитектур интерьерийн түүх,	Магистр	Архитектурын тэнхимийн багш	Танхим
3	О.Наранчимэг	Багш	4 жил	Архитектур төсөл	Магистр	Архитектурын тэнхимийн багш	Танхим
4	Л.Давааням	Багш	10 жил	Дүрс судлалын үндэс	Магистр	Дүрслэх урлагийн тэнхимийн багш	Танхим
5	Б.Баярцэцэг	Багш	2 жил	Өнгө судлалын үндэс	Магистр	Дүрслэх урлагийн тэнхимийн багш	Танхим
6	Г.Уянга	Багш	7 жил	Хятад хэл	Магистр	Архитектурын тэнхимийн багш	Танхим
7	Г.Батмөнх	Ахлах багш	4 жил	Туршилт тооцоо, Орон зайн бүтээц, Эргономик	Зөвлөх инженер	Архитектурын тэнхимийн багш	Танхим

8	Онуфриенко Данийл Евгеньевич	Багш	4 жил	Архитектур дизайн III	докторантур	Архитектурын тэнхимийн багш	Цахим
9	Ариунжаргал	Тэнхимийн эрхлэгч					

II. Оюутнуудтай хийх уулзалт

№	Овог нэр	Салбар	Мэргэшил	Курс
1	А.Гончигдорж	Архитектур тэнхим	Архитектур	4
2	Б.Болормаа		Архитектур	4
3	Манал		Архитектур	4
4	У.Мөнхдорж		Архитектур	3
5	Б.Хулангоо		Архитектур	2
6	Н.Номинцэцэг		Архитектур	2
7	Б.Батцэцэг		Архитектур	2
8	Х.Янжинлхам		Архитектур	2
9	Б.Хулан-Эрдэнэ		Архитектур	1
10	Х.Уянга		Архитектур	1
11	Э.Намуундарь		Архитектур	4
12	Ш.Амгаланбаяр		Архитектур	2
13	М.Ариунзул		Архитектур	2
14	Б.Өлзийхишиг		Архитектур	2
15	А.Тулгаа		Архитектур	4

III. Ажил олгогчидтой хийх уулзалт

№	Овог нэр	Албан тушаал	Албан газар	Утас, Имейл хаяг
1	П.Ариунболд	Захирал	Динновэйшн ХХК	88118126 ariunbold@dib.mn
2	Н.Энхтэгш	Захирал	Хүн хот ХХК	99067897 Tegshcad@gmail.com
3	Л.Энхтөр	Захирал	Марч архитект ХХК	99775295 Eturuu123@gmail.com
4	Л.Бямбадорж	Захирал	Гурба ХХК	88506644 L.byambadorj@gurba.mn
5	Д.Буянжаргал	Ерөнхий архитектор	Векэн ХХК	95255426 Buyana0205@gmail.com
6	Л.Давхарбаяр	Захирал	Зип ХХК	88098737 zipstudiomn@gmail.com
7	В.Баасанбаатар	Захирал	Альфа скай буйлдинг ХХК	89100817 ingenerbaasanbaatar@gmail.com

IV. Төгсөгчидтэй хийх уулзалт

№	Нэр	Төгссөн он	Мэргэшил	Ажил, албан тушаал	Албан газар
1	Б.Эрдэнэжин	2016	Архитектур	Ерөнхий архитектор	М ЖИ ЭЛ ХХК
2	Т.Мөнхбаян	2015	Архитектур	Архитектор	Арвайхээр хотын захирагчийн ажлын алба
3	Г.Дашням	2015	Архитектур	Норм нормативийн хэлтсийн мэргэжилтэн	Барилгын хөгжлийн төв ТӨҮГ
4	Б.Энхчимэг	2018	Архитектур	Архитектор	Хоргын чулуу ХХК
5	Б.Бямбадорж	2016	Архитектур	Архитектор	Гурба ХХК
6	Т.Өнөр-Од	2021	Архитектур	Архитектор	Монгол наадам ХХК
7	А.Ану	2020	Архитектур	Архитектор	Magnus centurion construction
8	Ж.Пунсал	2018	Архитектур	Архитектор	Нарлаг хөхий ХХК
9	Д.Гомбосүрэн	2019	Архитектур	Архитектор	Монполимент групп
10	Уламбаяр	2017	Архитектур	Ахлах архитектор	Диновэйшн ХХК
11	Хос-Амгалан	2020	Архитектур	Архитектор	Өрнөх гүнт ХХК
12	Б.Буяндэлгэр	2015	Архитектур	Архитектор	Модерн хоум ХХК
13	Б.Саруул	2019	Архитектур		

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



**ИХ ЗАСАГ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ДҮРСЛЭХ УРЛАГ, ДИЗАЙН
ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬ**

13381 ш/х-349, Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, 4 дүгээр хороо, Б.Доржийн гудамж,
Утас/Факс: (976) 7015 1919,
E-mail: ikhzasag@ikhzasag.edu.mn,
http://www.ikhzasag.edu.mn

дэд. 01.04 № 02
танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

Тус сургуулийн архитектурын хөтөлбөрт (Индекс:073101) 2021.12.09-10-нд хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн тайлантай бид танилцлаа. Шинжээчийн багийн гаргасан зөвлөмж, шаардлагатай санал нийлж буйгаа үүгээр илэрхийлэхийн сацуу зөвлөмжийн дагуу сайжруулалтыг хийхээ илэрхийлж байна.

Архитектурын хөтөлбөрийн хамт олон

ЗАХИРАЛ



Б.ГАНТУЛГА /Ph.D/

D:\AJL\Ywuulsan bichig\2021\docx